


Боржигин чуулгын даргын 2019 оны
09 сарын 12 ны өдрийн
№55 тоот тушаалын 2-р хавсралт

**ЧУУЛГЫН ТОГЛОЛТ, УРАН БҮТЭЭЛ, УРАН БҮТЭЭЛЧДИЙГ
ТҮРЭЭСЛЭХ ЖУРАМ**



НЭГ. ЗОРИЛГО

Мэргэжлийн урлагийн байгууллага нь өв соёлоо суртчилан түгээн дэлгэрүүлэх, өөрийн орлогыг бүрдүүлэх, Аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэдэд соёл урлагийн үйл ажиллагаа, арга хэмжээнд нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Дуу Бүжгийн Боржигин чуулга нь Боржигин өв соёлын давтагдашгүй өвөрмөц онцлогыг тусгасан уран бүтээл, дэлхийн болон монгол сонгодог, орчин үеийн олон талт урсгал чиглэлээр уран бүтээлүүдийг туурвин соёл урлагийн үйлчилгээ, үйл ажиллагааг зохион явуулдаг. Соёл урлагийн үйл ажиллагаа, уран бүтээлийг зохих зөвшөөрлийн дагуу байгууллага, хувь хүнтэй гэрээ үйлдэж доорхи үнэ тарифыг мөрдлөг болгоно.

ГУРАВ. ТҮРЭЭСЛЭГЧИЙН ҮҮРЭГ

- 3.1 Түрээслэгч нь үйл ажиллагаа болох хугацаа, шаардлагатай тоглолт, уран бүтээлүүдийг хүсэлт гарган байгууллагын даргын зөвшөөрөл авна.
- 3.2 Түрээслэгч зөвшөөрөгдсөн тохиолдолд чуулгын маркетингийн менежертэй доорхи үнэ тарифын дагуу үйл ажиллагааны цаг хугацаа, уран бүтээлийг тодорхой заасан гэрээ хийн гэрээний дагуу үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь төлөх

ДӨРӨВ. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ

- 4.1 Түрээслэгч талын хүсэлтийн дагуу зохих зөвшөөрөлийг олгоно.
- 4.2 Түрээслэгчийн хүсэлтийн дагуу тоглолт, үйл ажиллагааг ажлын хуваарьт тусган, уран бүтээлчдийг цаг хугацаанд нь бэлэн байлгах
- 4.3 Түрээслүүлэгч нь гэрээнд заасны дагуу цаг хугацаанд нь тоглолт, уран бүтээлүүдийг чанартай, зохион байгуулалттай үйлчилгээ үзүүлэх,